



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/367

Мандалговь

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1, 38.2, 38.4 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэр (Их тойруу-5-511в)-д байршилтай Дундговь аймгийн хүнс хөдөө аж ахуйн газар (РД:9033114)-ийн өвс тэжээлийн агуулахын зориулалттай 3000 м.кв (0,3га) газрыг Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газар (РД: 9033556)-т зориулалтаар нь шилжүүлж 29 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, бөгөөд Мандалговь хотын захирагч (С.Бат-Оргил), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/85 дүгээр захирамжийн иргэн Дундговь аймгийн хүнс хөдөө аж ахуйн газар-т холбогдох хэсэг мөн газар эзэмших 000010218 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822111221